



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/72

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл  
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хандү ХХК-ийн “Хандү” зочид буудлын 17/172, МҮЭХ-ҮҮТөвийн “Альфа” зочид буудлын 17/184, Эль хаус ХХК-ийн “Эль хаус” зочид буудлын 17/189, Гэрэлт хүсэл ХХК-ийн “Хур” дэн буудлын 17/157 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг

1150500233

Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.


6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 08  
сарын 28 өдрийн А/72 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.08.28

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хандү ХХК	6188575	Хандү	БГД-ийн 6-р хороо Чингүнжавын гудамж 308
2	МҮЭХ-ҮҮТөв	1067273	Альфа	СБД-ийн 1-р хороо Нарны зам 64
3	Эль хаус ХХК	2856352	Эль хаус	БГД-ийн 17-р хороо Амарсанаагийн гудамж 23-1

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 08  
сарын 28 өдрийн А/72 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ 8926 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.08.28

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Баянхан ундарга ХХК	6337139	Хотел 28	БГД-ийн 7-р хороо 3-р хороолол 29-300
2	Жасиун ХХК	5906326	Жасиун	СБД-ийн 13-р хороо рашаан 16-798
3	Оюу угтуул ХХК	6327966	Найз	БГД-ийн 6-р хороо ЭТӨЧ 75-1
4	Номин говь ХХК	2576082	Ноён	БГД-ийн 5-р хороо АОС 13
5	Гэрэлт хүсэл ХХК	2727528	Хур	БГД-ийн 12-р хороо Хасбаатарын гудамж 5-1